

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани



"МЭДЭЭЛЭЛ-АУДИТ" ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Бүтээлч үйлс" ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар
болсон санхүүгийн тайлан

Улаанбаатар хот

2026 он



МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК

“БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчид танаа

2026.04.29 № 34.
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

“БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК-ийн (цаашид компани гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК-ийн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулийн эдгээр шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 169.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Бэлэн мөнгөний үлдэгдэл 1,211.7 сая төгрөг бодитоор оршин байгаа нь нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, 5 дугаар зүйл 5.1.4 үнэн зөв байх зарчим,” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Аудиторын зорилго нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үл үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад оршино. Үл үндэслэлтэй баталгаа нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь материаллаг болж, эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэл болж болзошгүй гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болж, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглаж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоололын үл үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл Аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртлэх олж авсан Аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Санхүүгийн тайлангийн аудитын үед аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг ММНБИ-ийн monicpa.mn сайтад байрлах манай аудитын компанийн холбоосонд байрлуулсан бөгөөд энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл нь бидний аудиторын тайлангийн хэсэг болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг МУ-ын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох "Бүтээлч үйлс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



ГҮЙЦӨТГЭХ ЗАХИРАЛ, МНБ

Д.ТОВУУДОРЖ

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2024.12.31	2025.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,496,805,375.71	1,214,446,863.48
1.1.2	Дансны авлага	1,500,000.00	2,492,750.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	7,250.00
1.1.6	Бараа материал	152,561,192.92	709,944,835.02
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,911,935,214.73	1,641,393,825.29
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,562,801,783.36	3,568,285,523.79
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		-
1.2.1	Үндсэн хөрөнгө	240,702,809.09	229,681,667.62
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	240,702,809.09	229,681,667.62
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,803,504,592.45	3,797,967,191.41
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,156,088,532.00	1,131,088,532.00
2.1.1.3	Татварын өглөг	46,694,771.63	5,771,061.02
2.1.1.4	НДШ-н өглөг	2,199,000.00	2,599,790.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	64,426,233.48	65,688,246.48
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,269,408,537.11	1,205,147,629.50
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	5,420,000,000.00	5,728,850,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,420,000,000.00	5,728,850,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,689,408,537.11	6,933,997,629.50
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : а) төрийн		
2.3.2	б) хувийн	89,362,998.76	89,362,998.76
2.3.3	б) хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	78,920,257.00	78,920,257.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,054,187,200.42)	(3,304,313,693.85)
2.3.10			-
2.3.11	Эздийн өмчийн дүн	(1,885,903,944.66)	(3,136,030,438.09)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,803,504,592.45	3,797,967,191.41

Алслагдсан Аудит

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025
1	Борлуулалтын орлого (цэвэр)	912,798,636.35	1,150,146,155.27
2	Борлуулалтын өртөг	261,610,635.69	302,083,201.89
	Үзүүлсэн ажил үйлчилгээний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	651,188,000.66	848,062,953.38
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	895,005.42	63,949.57
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,437,573,247.36	2,095,347,014.58
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		2,910,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(832.00)	3,618.20
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(785,491,123.76)	(1,250,126,493.43)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(785,491,123.76)	(1,250,126,493.43)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(785,491,123.76)	(1,250,126,493.43)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(785,491,123.76)	(1,250,126,493.43)

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	89,362,998.76	78,920,257	(1,268,696,076.66)	(1,100,412,820.90)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл	89,362,998.76	78,920,257	(1,268,696,076.66)	(1,100,412,820.90)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(785,491,123.76)	(785,491,123.76)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	89,362,998.76	78,920,257.00	(2,054,187,200.42)	(1,885,903,944.66)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл	89,362,998.76	78,920,257.00	(2,054,187,200.42)	(1,885,903,944.66)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,250,126,493.43)	(1,250,126,493.43)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	89,362,998.76	78,920,257.00	(3,304,313,693.85)	(3,136,030,438.09)

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2024	12/31/2025
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,033,603,870.33	1,266,422,783.54
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,033,603,870.33	1,266,422,783.54
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,494,955,770.26	2,709,930,190.54
	Ажиллагчдад төлсөн	86,540,190.00	104,557,965.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	24,669,700.00	31,284,560.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	108,798,534.04	653,580,799.90
	Ашиглалтын зардалд төлсөн	52,924,859.56	82,086,686.38
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	54,921,480.01	13,053,544.55
	Хүүний төлбөрт төлсөн	832,323,894.65	1,613,731,587.78
	Татварын байгууллагад төлсөн	86,594,676.28	164,754,260.24
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	248,182,435.72	46,880,786.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(461,351,899.93)	(1,443,507,407.00)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	895,005.42	63,949.57
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	895,005.42	63,949.57
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.30	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгө гүйлгээний дүн	895,005.42	63,949.57
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,235,663,154.86	15,026,802,661.64
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,235,663,000.00	15,026,798,043.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	154.86	4,618.64
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,649,287,440.19	14,865,717,716.44
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,557,696,401.65	14,717,948,043.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	91,590,001.20	147,768,673.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,037.34	1,000.44
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,586,375,714.67	161,084,945.20
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,125,918,820.16	(1,282,358,512.23)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	370,886,555.55	2,496,805,375.71
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,496,805,375.71	1,214,446,863.48

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани ба түүний үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани (цаашид "Компани" эсвэл "ХК")-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

Тус компани нь анх 1941 онд налайхын нүүрсний уурхайг түшиглэн байгуулагдаж байсан бөгөөд 1992 оноос "Бүтээлч үйлс" нэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2006 оны 03 дугаар сарын 23-нд 89,362.9 мянган төгрөгийн дүрмийн сантай, 1 гишүүнтэйгээр улсын бүртгэлд бүртгүүлсэн. Улсын бүртгэлийн 2910001001 дугаартай гэрчилгээтэй.

Компанийн хувь эзэмшигчдийн нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 191,180 ширхэг энгийн хувьцаанаас бүрддэг. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн дараах байдалтай байна.

№	Овог	Нэр	Хувьцааны тоо /ширхэг/	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Дамдиндорж	Эрдэнэбилэг	38220	20%
2	Пүрэвжав	Оюунхүү	37221	19%
3	Дамдиндорж	Эрдэнэтулга	33752	18%
4	Бусад хувьцаа эзэмшигч-568 хүн		90013	43%
НИЙТ				100%

ХК-ийн дээд удирдлага нь Хувьцаа эзэмшигчид байх бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн гүйцэтгэх удирдлага дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбилэг
- Дэд захирал М.Нэргүй

Үндсэн үйл ажиллагаа. ХК нь компанийн дүрэмд заасан, улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн үндсэн үйл ажиллагааны нь дараах чиглэлүүд боловч гол явуулж буй үндсэн үйл ажиллагаа нь бүх төрлийн бэлэн хувцасны үйлдвэрлэл байна.

- Хүнсний дэлгүүр
- Гадаад худалдаа
- Бүх төрлийн бэлэн хувцасны оёдол эрхлэх

Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Эрчим хүчний зүүн талд өөрийн байранд

Утас: 99091130, 70110147

Э-мэйл: buteelch_uits@yahoo.com

Web: www.buteelch.mn

Тайланд хэрэглэсэн толилуулгын валют. Санхүүгийн тайланд тухайлан өөрөөр заагаагүй бол тайлангийн үзүүлэлтүүдийг Монгол төгрөгөөр илэрхийлнэ.

1 Тасралтгүй байх зарчим

Компани 2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд 1,250.1 сая төгрөгийн алдагдалтай байгаа нь компанийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх чадавхид эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхойгүй байдал оршин байгааг харуулж байна.

Иймд, хэрэв нэмэлт санхүүжилт хийгдэх боломжгүй эсвэл тасралтгүй байх зарчмаар үйл ажиллагаа үргэлжлэх боломжгүй тохиолдолд үүсч болох хөрөнгө болон өглөгийн ангилал, хэмжээтэй холбоотой аливаа залруулгыг энэхүү санхүүгийн тайланд тусгаагүй болно.

(Red stamp)

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

2.1 Тайланд мөрдсөн стандарт: Компанийн санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

2.2 Тайлан бэлтгэх үндэслэл: Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу худалдан авсан түүхэн өртгийг бүртгэх зарчмаар бэлтгэгдсэн. Энэхүү санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд мөрдсөн гол бодлогуудыг дор тодруулж үзүүлсэн бөгөөд тусгайлан заагаагүй тохиолдолд тэдгээрийг тайлагнаж буй бүх тайлант хугацаанд тууштай мөрдсөн.

2.3 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө: Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсэд гар дээр байгаа бэлэн мөнгө, банкны харилцах болон хугацаагүй дансны хадгаламж, 3 сар ба түүнээс богино хугацаанд төлөгдөх богино хугацаат болон түргэн хөрвөх бусад хөрөнгө оруулалтуудыг хамруулна.

2.4 Үндсэн үйл ажиллагааны дансны авлага ба бусад авлага: Үндсэн үйл ажиллагааны дансны авлага ба бусад авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэнэ. МБМ-д оруулсан хөрөнгө оруулалтыг гэрээгээр тохиролцсон ханшаар тэгшигтгэж бүртгэсэн.

2.5 Бусад санхүүгийн хөрөнгө: Үүнд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хамаарна. Санхүүгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахад СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Топилуулга – ийг дагаж мөрдөнө.

МГМ-ын санхүүгийн хөрөнгө нь Санхүүгийн тайланд "Бусад санхүүгийн хөрөнгө" ба "Бусад эргэлтийн бус хөрөнгө" дансанд бүртгэгдэн тайлагнагдсан.

2.6 Бараа материал: Бараа материалыг өртгөөр нь бүртгэдэг. Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, үйлдвэрлэлийн зардал, бусад зардал буюу одоогийн байршил, нөхцөлд авч ирэхтэй холбогдож гарсан зардал орно. Бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа хөрөнгө, борлуулалтын зорилгоор үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс, үйлдвэрлэлийн дамжлага эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал болон хангамжийн зүйлс багтана.

2.7 Урьдчилж төлсөн зардал/тооцоо:

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

2.8 Үндсэн хөрөнгө. Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнадаг.

Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар.
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Үндсэн хөрөнгийн өртөг нь мэргэжлийн үйлчилгээний төлбөр, капиталжуулсан эзэлийн хүүгийн зардал, бэлтгэл ажиллагааны зардлыг багтаасан байна. Үндсэн хөрөнгө нь ашиглахад бэлэн суурилагдсан үед тохирох үндсэн хөрөнгийн төрөлд нь ангилан бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийг данснаас хассаны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулж тооцох ба олз, гарзыг бусад үйл ажиллагааны зардлын хэсэгт тухайн жилийн орлого, зарлагаар бүртгэдэг.

Элэгдэл. Газрыг элэгдүүлдэггүй ба харин үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо дор харуулсан тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл элэгдүүлдэг.

Үүнд:

(Харгалдан үзүүлнэ)

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

№	Үндсэн хөрөнгийн төрөл зүйл	Элэгдэл байгуулах жил
1	Барилга, байгууламж	25-40
2	Машин, механизм, тоног төхөөрөмж	10
3	Тавилга эд хогшил	10
4	Компьютер, түүний эд анги, програм хангамж	2
5	Ашиглалтын лиценз	Лицензийн хүчинтэй хугацаанд
6	Бусад үндсэн хөрөнгө	10

2.9 Биет бус хөрөнгө. Компанийн биет бус хөрөнгө нь ашигтай ашиглагдах тодорхой хугацаатай байх ба ашиглалтын лиценз болон компьютерын програм хангамж орно.

Худалдан авсан програм хангамжийн тусгай зөвшөөрлүүд ба бусад биет бус хөрөнгийг бүртгэхдээ тэдгээрийг худалдан авсан үнэ дээр ашиглалтад оруулахтай холбоотой гарсан зардлыг нэмсэн дүнгээр капиталжуулж бүртгэдэг.

Компани ашиглаж, хянаж буй ижил төрлийн болон тусгай програм хангамжтай шууд холбоотой боловсруулах үйл ажиллагааны зардлыг, хэрэв гарсан зардлаас давсан эдийн засгийн нэмэлт олз орж ирэх өндөр магадлалтай бол, биет бус хөрөнгөөр бүртгэнэ. Капиталжуулсан зардалд програм хангамж боловсруулж буй ажилтанд хөдөлмөрийн хөлс төлөх зардал ба нэмэлт зардал дахь зохих хувь хэсэг тус бүр орно. Програм хангамжтай холбоотой, тухайлбал техник арчилгаатай холбоотой бусад бүх зардал тухайн үеийн зардалд багтана.

Компани ашиглалтын лицензийн хүчинтэй хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдлийг тооцож байгаа бөгөөд цаашид олборлолтын хэмжээнд хувь тэнцүүлэн элэгдэл байгуулах нь санхүүгийн байдлыг илүү бодитой тайлагнахад чухал ач холбогдолтой болно.

Биет бус хөрөнгийг тэдгээрийн ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

Биет бус хөрөнгийн төрөл зүйл	Ашиглалтын хугацаа (жилээр)
Програм хангамж	2
Лиценз /Тусгай зөвшөөрөл/	Лицензийн хүчинтэй хугацаанд

Үнэ цэнэ буурсан тохиолдолд биет бус хөрөнгийн бүртгэлийн дүнг ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс худалдахад гарах зардлыг хассан дүнгийн аль ихээр нь тусгана.

2.10 Санхүүгийн хэрэгсэл: Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өрийг санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл бас өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

2.11 Санхүүгийн хөрөнгө: Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран санхүүгийн хөрөнгийг анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Мэргэжлийн Архив

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

2.12 Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл: Өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээгээр хүлээсэн нөхцөлийн бодит байдал ба санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтод үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилдаг.

2.12.1 Санхүүгийн өр төлбөр: Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртөөр бүртгэнэ. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрдэнэ.

Борлуулах зориулалттай өр төлбөрийг бүртгэхдээ жилийн ашиг, алдагдал (санхүүгийн орлого болон санхүүгийн зардал)-ыг хамаарах цаг хугацаа болон бодит үнэ цэнээр тусгадаг. Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасахдаа зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасч буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.12.2 Өмчийн хэрэгсэл: Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэнэ. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр бүрддэг.

2.13 Орлого хүлээн зөвшөөрөлт:

СТОУС 15-ын дагуу Компани нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гэрээний хөрөнгө нь хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн боловч бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээтэй холбоотой төлбөрийг Компани хүлээн авах эрх үүсээгүй үед бий болох хөрөнгө юм. Үг гэрээний хөрөнгийг дансны авлагаар бүртгэж үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу хэмжинэ.

Гэрээний өр төлбөр нь худалдан авагчаас төлбөр хүлээн авсны хариуд худалдан авагчид барааг шилжүүлэх үүргийг илэрхийлнэ. Бараа бүтээгдэхүүнийг борлуулахаас өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж "Урьдчилж орсон орлого" дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа бүтээгдэхүүнийг борлуулсан буюу орлого хэрэгжсэн үед дебетлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэнэ.

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, борлуулалтын хөнгөлөлт, эдгээртэй ижил төстэй хөнгөлөлтүүдийг хассан цэвэр дүнгээр бүртгэдэг. Хэрэв хөнгөлөлт үзүүлэх нь магадлалтай, мөн дүнг нь найдвартай хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрөхдөө уг хөнгөлөлтийг орлогоос хасч бүртгэнэ.

2.14 Зардал хүлээн зөвшөөрөлт: Зардлыг орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан бараа бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Компанийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

2.15 Гадаад валютын ханшны хөрвүүлэлт: Компанийн үйл ажиллагааны тайлагналын мөнгөн тэмдэгт нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны мөнгөн нэгж юм. Компанийн үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм.

Мөнгөн зүйлст тооцогдох хөрөнгө ба өр төлбөрүүдийг тухайн тайлант хугацаа бүрийн эцэст тухайн өдрийн Монгол банкны (цаашид "МБ" гэх) албан ханшаар Компанийн үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн харгалзах өдрийн Монгол банкны албан ханшид хөрвүүлснээс үүсэх гадаад валютын ханшийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлүүдийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлэхгүй. Тайлант хугацааны эцэс дэхь банк болон бэлэн мөнгөний үлдэгдлийг тодруулгын мөнгөн нэгж руу хөрвүүлэхэд ашигласан валютын ханш.

(Handwritten signature)

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

Он сар	Ам.доллар
2024 оны 12 дугаар сарын 30-ний өдөр	2,420.25
2025 оны 12 дугаар сарын 30-ний өдөр	3,556.66

2.16 Зээлийн зардал: Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг. Бусад зээлийн хүүг тайлант жилийн ашиг алдагдлын тайланд тусгана.

2.17 Ажиллагсдын тэтгэмж: Цалингаас тооцсон нийгмийн даатгалын санд шилжүүлэх шимтгэл, ээлжийн амралт, өвчтэй байсан хугацааны тэтгэмж, шагнал, түүнчлэн мөнгөн бус хөнгөлөлтүүд (эмнэлгийн ба бусад үйлчилгээ)-ийг тухайн төрлийн тэтгэмж, урамшууллыг тайлант жилд хүлээн зөвшөөрнө.

2.18 Нөөц: Компани нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

2.18.1 Нөхөн сэргээлтэд зориулсан нөөц сан: Хөрөнгийн худалдан авалт, барилга угсралт, бүтээн байгуулалт эсвэл хөрөнгийн энгийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан үүргийн дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй уул уурхайн хөрөнгө болон ашигт малтмалын хөрөнгүүдийн нөхөн сэргээлттэй холбоотойгоор гэрээний, хуулийн эсвэл үүсмэл үүргийн биелэлтэд зориулж Компани нөөц сан байгуулдаг. Нөхөн сэргээх үүрэгт зориулсан нөөцийг анхлан тухайн үүрэг үүссэн үед уурхайн ашиглах хугацааны таамагласан мөнгөн урсгалыг зах зээлийн зохих хүүг ашиглан дискаунтласан мөнгөн урсгалын аргаар тооцсон цэвэр өнөөгийн үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг.

2.19 Холбоотой талуудын ажил гүйлгээ: Компани болон Компанитай холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг, эсвэл
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, эсвэл
- Компани болон Компаний толгой компанийн удирдах ажилтан.

Дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан аж ахуйн нэгж нь Компанийн холбоотой тал болно. Үүнд:

Бүтээлч үйлс
2024

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан компани бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан компани бол;
- Хоёр аж ахуй нэгж нь хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх; ба
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан.

2.20 Татвар: Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

2.20.1 Тухайн жилийн орлогын албан татвар: Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

2.20.2 Хойшлогдсон татвар: Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийг дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах орлого ба бүртгэлд тусгагдах ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээнээс үүссэн бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүний хувьд эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэггүй. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө нь хэрэгжих эсвэл өр өлбөр нь барагдах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар Компани хэрхэн хөрөнгийг нөхөх, өр төлбөрийг барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

2.20.3 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар: Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь орлого эсвэл өмчийн хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

3 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд

Компани нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд нөлөөлөх таамаглал болон тооцооллуудыг байнга хийдэг. Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Handwritten signature and date

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан компани бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан компани бол;
- Хоёр аж ахуй нэгж нь хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх; ба
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан.

2.20 Татвар: Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

2.20.1 Тухайн жилийн орлогын албан татвар: Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

2.20.2 Хойшлогдсон татвар: Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийг дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах орлого ба бүртгэлд тусгагдах ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээнээс үүссэн бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүний хувьд эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэггүй. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө нь хэрэгжих эсвэл өр өлбөр нь барагдах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар Компани хэрхэн хөрөнгийг нөхөх, өр төлбөрийг барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

2.20.3 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар: Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь орлого эсвэл өмчийн хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

3 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд

Компани нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд нөлөөлөх таамаглал болон тооцооллуудыг байнга хийдэг. Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцоолоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Харгалзсан бүртгэл

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

№	Төрөл	2024.12.31		2025.12.31	
		Валютаар	Төгрөгөөр	Валютаар	Төгрөгөөр
1	Кассад байгаа бэлэн мөнгө		2,491,943,334.26		1,211,786,384.60
2	Банкин дахь мөнгө		119,129.93		1,320,365.98
3	Мөнгө түүнтэй адилтгах				
	Дүн		2,492,062,464.19		1,213,106,750.58

6. Дансны авлага

№	Авлагын ангилал	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулга	Дансны авлага /цэвэр/
1	Эхний үлдэгдэл	1,500,000.00		1,500,000.00
2	Нэмэгдсэн	992,750.00		992,750.00
3	Хасагдсан	-		-
	Төлөгдсөн	-		-
	Найдваргүй болсон	-		-
4	Эцсийн үлдэгдэл	2,492,750.00		2,492,750.00

7. Бараа материал

№	Үзүүлэлтүүд	Бараа материалын төрөл		Нийт
		Түүхий эд материал	Бэлэн бүтээгдэхүүн	
1	Эхний үлдэгдэл/өртөг/	124,517,970.61	28,043,222.31	152,561,192.92
2	Нэмэгдсэн дүн	1,160,903,998.58	321,990,034.59	1,482,894,033.17
3	Хасагдсан дүн	623,427,189.19	302,083,201.88	925,510,391.07
4	Эцсийн үлдэгдэл	661,994,780.00	47,950,055.02	709,944,835.02
5	Үнийн бууралтын гарз			-
6	Үнийн бууралтын буцаалт			-
7	Дансны цэвэр дүн			-
8	Эхний үлдэгдэл	661,994,780.00	47,950,055.02	709,944,835.02
9	Эцсийн үлдэгдэл	661,994,780.00	47,950,055.02	709,944,835.02

8. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
4	Урьдчилж төлсөн тооцоо	1,911,935,214.73	1,641,393,825.29
5	Нийт	1,911,935,214.73	1,641,393,825.29

9. Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Барилга байгууламж	362,243,349	362,243,349
ХЗ-Барилга байгууламж	(123,505,596)	(132,561,681)
Машин, тоног төхөөрөмж	40,290,000	40,290,000
ХЗ-Машин, тоног төхөөрөмж	(38,324,942)	(40,290,000)
Тээврийн хэрэгсэл	22,000,000	22,000,000
ХЗ-Тээврийн хэрэгсэл	(22,000,000)	(22,000,000)
Нийт дүн	240,702,810	229,681,667

10. Дансны өглөг

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Хугацаандаа байгаа	1,156,088,532	1,131,088,532
4	Нийт	1,156,088,532	1,131,088,532

11. Татварын өр

Ш.Амгалан Аюуш

"Бүтээлч үйлс" Хувьцаат компани

№	Татварын өрийн төрөл	2024.12.31	2025.12.31
1	НӨАТ	43,270,931.63	4,170,606.02
2	ХХОАТ	3,423,840.00	1,600,455.00
3	НДШ өр	2,199,000.00	2,599,790.00
	Нийт өр	48,893,771.63	8,370,851.02

14. Урт хугацаат зээл

№	Ангилал	2024.12.31		2025.12.31	
		Төгрөг	Валют	Төгрөг	Валют
1	Дотоодын эх үүсвэрээс	5,420,000,000		5,728,850,000	

15. Эздийн өмч

Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Өмч			
а/ төрийн			
б/ хувийн		89,362,999	89,362,999
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		78,920,257	78,920,257
Тайлант үеийн хуримтлагдсан ашиг /алдагдал/			
Дүн			

16. Борлуулалтын орлого

Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Борлуулалтын орлого		912,798,636	1,150,114,337
Нийт борлуулалтын өртөг		912,798,636	1,150,114,337

17. Борлуулалтын өртөг

Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		261,610,635	302,201,828
Нийт борлуулалтын өртөг		261,610,635	302,201,828

18. Бусад орлого

Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Хүүний орлого		895,005	63,949
Бусад орлого			
Бусад орлогын дүн		895,005	63,949

19. Борлуулалт ба ерөнхий удирдлагын зардал

Үзүүлэлт		2025.12.31
Ажиллагсадын цалин		128,010,000
Аж ахуй нэгжээс төлсөн НДШ		16,972,050
Томилолтын зардал		
Бичиг хэргийн зардал		3,464,636
Шуудан холбооны зардал		3,021,470
Деатгалын зардал		
Ашиглалтын зардал		82,086,686
Харуул хамгаалалтын зардал		
Засварын зардал		33,551,493
Элэгдэл хорогдлын зардал		11,021,141
Түрээсийн зардал		156,996,679

Монгол Аудит
2025

“Бүтээлч үйлс” Хувьцаат компани

Шатахууны зардал		13,053,545
Зар сурталчилгааны зардал		2,817,182
Зээлийн хүүний зардал		1,613,731,588
Түүхий эд материалын зардал		
Бусад зардал		30,620,544
Үйл ажиллагааны зардлын дүн		2,095,347,015

20.Балансын дараах үйл явц

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөө үзүүлэх үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд гараагүй гэж үзэж байна.

АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ННБОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар журам, СТОУС-уудын нэмэлт өөрчлөлтүүд мөрдөж ажиллах.
- Их хэмжээний бэлэн мөнгөөр гүйлгээ хийж байгаа нь бэлэн мөнгө шамшигдах эрсдэлтэй байгаа тул арилжааны банкаар гүйлгээ хийх.
- 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн эздийн өмч 3,136.0 сая төгрөгийн алдагдалтай байгаа нь Компанийн тухай хуулийн 31-р зүйлийн 31.3-т “Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ,МНБ

[Handwritten signature]

Д.ТОВУУДОРЖ